



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/45

Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт, төсөвт
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдана авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Засгийн газрын 2021 оны 359 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Төрийн үйлчилгээний тоног төхөөрөмж” худалдан авах ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсоргодог)-т даалгасугай.

3. “Төрийн үйлчилгээний тоног төхөөрөмж” худалдан авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар
сарын 07-ний өдрийн А/45... дугаар
захирамжийн хавсралт

“ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ”
НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД УЛСЫН ТӨСВИЙН
ХӨРӨНГӨӨР 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Үйл ажиллагаа	Тоо ширхэг	Шаардагдах хөрөнгө /сая. Төг/
1	Сумдын ЗДТГ, ИТХ, багийн Засаг дарга нарт зөөврийн компьютер худалдан авах	78	167,000,000
	Дрон (Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газарт)	1	3,200,000
2	Багийн Засаг дарга нарт мотоцикль	60	173,100,000
Нийт дүн			340,000,000

_____оОо_____